



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 4/14

Арвайхээр сум

Эд хөрөнгийн тооллогын комисс
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Татварын хэлтсийн 2022 оны А/10 дугаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 11 дүгээр зүйл, Татварын хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаартай Өмч хамгаалах зөвлөлийн шинэчлэн байгуулах тухай тушаал зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын хэлтсийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Т.Бадамхорол (Татварын хяналт шалгалтын тасгийн дарга)

Гишүүд: Б.Бямбасүрэн (Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч)

Л.Буянжаргал (Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)

Д.Болор-Эрдэнэ (Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцаагч)

Я.Чойсүрэн (Жолооч-слесарь)

2. Тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг дуустал зохион байгуулж, тооллогын дүнг нэгтгэн цаашид ашиглах боломжгүй, засварлах шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг гаргаж ажиллахыг (Т.Бадамхорол)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/24 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЭРДЭНЭСУВД



621001027